



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

“Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд
төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам” батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 5 дугаар зүйлийн 5.5.1 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 6.1.4 дэх заалт, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Дэд хөтөлбөр батлах тухай” 30/39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Төр, хувийн хэвшлийн түншлэлээр Нийслэлд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямба/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Журам батлах тухай” 81 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Р.ДАГВА

1110100023

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01
дүгээр сарын 15-ны өдрийн 70 дугаар
тогтоолын хавсралт

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР НИЙСЛЭЛД ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Нийслэлийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээ болон бусад салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төсвийн ачааллыг бууруулах, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих зорилгоор төр, хувийн хэвшлийн түншлэл (цаашид "ТХХТ" гэх)-ээр хөгжлийн төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлэх, үнэлэх, оролцогч талуудын эрх, үүрэг, төсөл, хөтөлбөр сонгон шалгаруулах зохион байгуулалтын үйл ажиллагаа, чиг үүргийн хуваарилалттай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Нийслэлд хэрэгжүүлэх ТХХТ-ийн төсөл, хөтөлбөр нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.2.1. Нийслэлийн төсөв, санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, орон нутгийн засаг захиргаа дангаараа хэрэгжүүлэхэд технологийн шийдэл, санхүүгийн хувьд бэрхшээлтэй, ТХХТ зайлшгүй шаардлагатай байх;

1.2.2. Нийслэл хотыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд нийцсэн байх;

1.2.3. Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1-д заасан орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарч байх;

1.2.4. Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, улс орны болон тухайн нутаг дэвсгэрийн хүн амын нийтлэг ашиг сонирхол, эрэлт хэрэгцээг хангасан байх;

1.2.5. Хэрэгжүүлэх бүрэн боломжтой, олон улсын стандартад нийцсэн, шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн дэвшилтэт ололтыг ашигласан байх;

1.2.6. Эдийн засаг, нийгмийн өндөр үр ашигтай болох нь техник, эдийн засгийн үндэслэлээр нотлогдсон байх;

1.2.7. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх явцад болон нутагшуулж хүлээлгэн өгөх хүртэлх баталгаат хугацаанд үүсэх аливаа эрсдэлийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч этгээд бүрэн хариуцахаар хүлээн зөвшөөрч байх;

1.2.8. Төсөл, хөтөлбөр бүрэн хэрэгжиж техник технологи нь нутагшин тухайн орон нутагт хүлээлгэн өгсний дараа гэрээний дагуух эргэн төлөгдөх нөхцөл хэрэгжиж эхэлнэ.

1.3. Концессын тухай хуулиар зохицуулсан концессын гэрээ байгуулах төсөл, хөтөлбөр, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төрлийн төсөл, хөтөлбөрүүд энэхүү журмын үйлчлэлд хамаарахгүй болно.

1.4. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг үнэлэх аргачлалыг энэ журмын хавсралтаар батална.

1.5.Төсөл, хөтөлбөр санаачлагч нь Нийслэлд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо, судалгааг төсөл, хөтөлбөр үнэлэх аргачлалын дагуу хийж ТХХТ-ийг Нийслэлд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Нийслэлийн байгууллагууд (цаашид "Нийслэлийн байгууллага" гэх)-д хүргүүлэх ба хүлээн авсан чиг үүрэг бүхий Нийслэлийн байгууллага нь зохион байгуулах, хэрэгжүүлэх ажиллагааг энэ журамд заасны дагуу зохион байгуулна.

ХОЁР. ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛЫГ ШИЙДВЭРЛЭХ

2.1.Нийслэлд ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг тухайн асуудлыг хариуцсан нийслэлийн, төрийн аль нэг байгууллага болон гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллага гаргаж болно.

2.2.Нийслэлд ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналыг чиг үүрэг бүхий Нийслэлийн байгууллага хүлээн авч төсөл, хөтөлбөрийг судална.

2.3.Нийслэлийн байгууллага нь төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгаа хийж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төсөл, хөтөлбөр хариуцсан нэгжээр дамжуулан Засаг даргын дэргэдэх удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ба шаардлагатай тохиолдолд Засаг дарга, төсөл, хөтөлбөртэй холбогдох чиг үүрэг бүхий алба нэгжийг багтаасан дүгнэлт гаргах эрх, үүрэг бүхий Ажлыг хэсэг байгуулна.

2.4.Нийслэлийн Засаг даргын дэргэдэх удирдах зөвлөлийн хурлаас дэмжигдсэн төсөл, хөтөлбөрийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн ТХХТ-ээр хэрэгжүүлэх эсэх тухай шийдвэр гаргана.

2.5.Нийслэлийн байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан этгээдүүдээс ирүүлсэн төсөл, хөтөлбөрийг судалж, үнэлгээ хийн дараах агуулгаар төсөл, хөтөлбөрийг ангилан холбогдох арга хэмжээг авна. Үүнд:

2.5.1.Нийслэлд хэрэгжүүлэх шаардлагатай боловч үр ашгийн хувьд хувийн хэвшлийн сонирхлыг татахгүй эсвэл нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтаар хийх шаардлагатай эсвэл концессын төсөл, хөтөлбөр. Энэ хэлбэрийн төсөл, хөтөлбөрийг төсөл, хөтөлбөр санаачлагчид буцааж нийслэлийн холбогдох газарт шилжүүлэх тухай зөвлөмж өгнө.

2.5.2.ТХХТ-ээр хэрэгжүүлэхэд бэлэн төсөл, хөтөлбөр. ТХХТ-ээр хэрэгжүүлэх төрөл, хэлбэрийг тодорхойлж цаашид хэрэгжүүлэх шийдвэр гаргуулахаар үр ашгийн тооцоолол болон холбогдох эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргахад шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төсөл, хөтөлбөр хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.5.3.ТХХТ-ийн зарчмаар хэрэгжүүлэх бололцоотой боловч зах зээлийн болон бусад судалгаа, нэмэлт тодруулга хийх төсөл, хөтөлбөрийг санаачлагчтай хамтран ТХХТ-ээр хэрэгжүүлэхэд бэлэн төсөл, хөтөлбөр болгон дахин үнэлгээ хийнэ.

2.5.4.Нийслэлд хэрэгжүүлэх боломжгүй, шаардлагагүй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжгүй шалтгааныг тодорхойлж төсөл, хөтөлбөр санаачлагчид буцаана.

2.6. Нийслэлийн байгууллага нь уралдаант шалгаруулалт явуулах замаар эсхүл хууль болон холбогдох баримт бичигт заасан арга замаар төсөл, хөтөлбөрийг хамтран болон дангаар хэрэгжүүлэх этгээдийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулна.

ГУРАВ. ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний чөлөө цагт Тэргүүлэгчид дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1.Нийслэлийн байгууллагын санал болгосон төслүүдтэй танилцаж, шийдвэр гаргах;

3.1.2.Хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн тайлантай хагас, бүтэн, жилээр танилцах.

3.1.3. Хуульд заасан бусад бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

3.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1.Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч, гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

3.2.2.Шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын болон нийслэлийн төсөвт тусгуулах;

3.2.3.Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад бий болсон хөдлөх, үл хөдлөх болон эдийн бус хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгүүлэх ажлыг зохион байгуулах;

3.2.4.Хуульд заасан бусад бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

3.3. Төсөл, хөтөлбөрийн талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн байгууллага, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба, түүний нэгжүүд дэмжлэг үзүүлж ажиллана.

ДӨРӨВ. ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

4.1.ТХХТ-ийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх Нийслэлийн байгууллага нь "Төсөл, хөтөлбөр дангаар болон хамтран хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг"-ийг (цаашид "Ажлын хэсэг" гэх) байгуулан ажиллуулна.

4.2.Төсөл, хөтөлбөр дангаар эсхүл хамтран хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий 5 буюу түүнээс дээш сондгой тооны бүрэлдэхүүнтэй байна.

4.3.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн төсөл, хөтөлбөрийн онцлог, шинж чанараас шалтгаалан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллага болон Нийслэл, хувийн хэвшлийн мэргэжлийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй байж болох бөгөөд гишүүн тус бүр саналын тэнцүү эрхтэй оролцоно.

4.4.Ажлын хэсгийн үйл ажиллагааг энэ журмаар зохицуулах бөгөөд журмаар зохицуулаагүй харилцааг Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан уралдаант шалгаруулалтын журмаар зохицуулна.

4.5. Ажлын хэсгийн гишүүн нь төсөл, хөтөлбөрийн саналыг үнэлэх чадвартай, тухайн салбарт мэргэшсэн, сүүлийн 3 жилийн хугацаанд шалгаруулалтад оролцогчтой хөдөлмөрийн гэрээний харилцаанд ороогүй ажилтан байна.

4.6. Нийслэлийн байгууллага нь төсөл, хөтөлбөрийн нөхцөлийг хамгийн сайн харилцан тохирсон оролцогчтой гэрээг байгуулснаар Ажлын хэсгийн бүрэн эрх дуусгавар болно.

4.7. Нийслэлийн байгууллага нь оролцох санал гаргагч, оролцогчоос шалгаруулалттай холбоотой гомдол хүлээн авч гомдлыг үндэслэлтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд Ажлын хэсгийн бие даасан үйл ажиллагаанд оролцохгүй.

4.8. Ажлын хэсгийн эрх:

4.8.1. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулж, батлуулах;

4.8.2. Шаардлагатай тохиолдолд оролцох хүсэлт гаргагчид болон оролцогчидтой уулзалт зохион байгуулах;

4.8.3. Оролцох саналыг нээх, үнэлэх, шаардлагатай тохиолдолд оролцох санал гаргагчаас тодруулга авах;

4.8.4. Хамгийн өндөр оноо авсан дарааллаар оролцогчтой хэлэлцээр хийж төсөл, хөтөлбөрийн болон гэрээний нөхцлийг хамгийн сайн харилцан тохирсон нэг оролцогчтой гэрээ байгуулах тухай дүгнэлт гаргана.

4.9. Ажлын хэсгийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдаанд гишүүдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

4.10. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулахдаа дараах дарааллыг баримтлана. Үүнд:

4.10.1. Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг боловсруулах, батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

4.10.1.1. Ажлын хэсэг нь төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах баримт бичгийг Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан Концесс олгох уралдаант шалгаруулалтын журмын хавсралтаар батлагдсан жишиг баримт бичгийн дагуу болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төсөл, хөтөлбөрийн төрөл, онцлогт тохируулан боловсруулж, батлуулна.

4.10.1.2. Ажлын хэсэг оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд оруулсан нэмэлт, өөрчлөлтөө батлуулж, оролцох санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш 5-аас доошгүй хоногоор сунгана.

4.10.1.3. Ажлын хэсэг баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүх оролцох хүсэлт гаргагчид нэгэн зэрэг мэдэгдэх бөгөөд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тухайн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.

4.10.2. Оролцох хүсэлт хүлээн авах, сонгон шалгаруулах баримт бичиг олгох;

4.10.2.1. Сонгон шалгаруулах урилгад холбогдох мэдээллийг тусган нийтэд мэдээлнэ.

- Төсөл, хөтөлбөрийн онцлог, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр нийслэлийн иргэдэд үзүүлэх ажил, үйлчилгээний тодорхойлолт;
- ТХХТ-ийн гэрээний ерөнхий нөхцөл;
- Оролцогчид тавих шаардлага;
- Хуулийн этгээдийн нэгдэл оролцож болох эсэх;
- Зөвхөн хязгаарлагдмал тооны этгээдийг оруулах эсэх;
- Хүсэлт хүлээн авах хаяг, хэлбэр, хугацаа;
- Шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл;

4.10.2.2. Урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлэхээс гадна, шаардлагатай бол олон улсад өргөн хэрэглэгддэг хэлээр гардаг тухайн салбарын хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж болно.

4.10.2.3. Сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлсэн этгээд саналыг хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө өгсөн саналаа буцаан авах, өөрчлөх, эсхүл дахин санал ирүүлэх эрхтэй.

4.10.2.4. Сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хугацаа нь түүнийг нийтэд зарласнаас хойш 15 хоногоос доошгүй байна.

4.10.2.5. Сонгон шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр нийтэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

4.10.2.6. Сонгон шалгаруулалтад нээлттэй өрсөлдөөн өрнүүлэх зорилгоор дотоод, гадаадын бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдыг уулзалт, ярилцлагад урих, бусад хэлбэрийн сурталчилгааг зохион байгуулж болно.

4.10.2.7. Оролцох хүсэлтийг сонгон шалгаруулалтын урилгыг нийтэд мэдээлснээс хойш оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа хүртэл саадгүй хүлээн авна.

4.10.2.8. Сонирхогч тал нь оролцох хүсэлтээ албан бичгээр гаргах бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичгийн үнийг төлсөн баримтыг үндэслэн төсөл, хөтөлбөрийн баримт бичгийг олгож бүртгэл хөтөлнө.

4.10.3. Оролцох санал хүлээн авах;

4.10.3.1. Оролцох хүсэлт гаргасан этгээд нь сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө оролцох саналаа уг баримт бичигт заасан шаардлагад нийцсэн тэмдэглэгээ, битүүмжлэлтэйгээр ирүүлнэ.

4.10.3.2. Оролцох хүсэлт гаргасан этгээд ирүүлсэн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө шинээр санал ирүүлж, өмнө ирүүлсэн саналаа буцаан авна.

4.10.3.3. Хугацаа хоцорсон эсхүл сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй тэмдэглэгээ, битүүмжлэлтэй оролцох саналыг хүлээж авахгүй.

4.10.3.4. Оролцох саналыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга бүртгэн хүлээж авна.

4.10.3.5.Оролцох санал хүлээн авах эцсийн хугацаанд багтаж ирсэн боловч бүртгэж амжаагүй оролцох саналыг санал хүлээн авах эцсийн хугацаагаар бүртгэнэ.

4.10.4.Оролцох саналыг нээх, үнэлэх, оролцогчийг сонгон шалгаруулах;

4.10.4.1.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан хаяг бүхий газар, товлосон хугацаанд оролцох санал гаргагчдын талаар мэдээлэл хийнэ.

4.10.4.2.Оролцох санал гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болон сонирхсон бусад этгээд мэдээлэл хийх үед байлцах эрхтэй.

4.10.4.3.Мэдээлэл хийх үед тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон мэдээлэл хийхэд байлцсан бусад этгээд гарын үсэг зурна. Оролцох санал гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсгээ зурахгүй байх нь тэмдэглэл хүчингүй болох үндэслэл болохгүй.

4.10.5.Төсөл, хөтөлбөрийн болон гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийх;

4.10.5.1.Ажлын хэсэг төсөл, хөтөлбөрт оролцох хүсэлтээ ирүүлсэн сонирхогч талуудын саналыг үнэлэн дараалуулсан жагсаалтын дагуу төсөл, хөтөлбөрийн болон гэрээний нөхцлийн талаар хэлэлцээ хийнэ.

4.10.5.1.1.Ажлын хэсэг нь хамгийн сайн нөхцөл санал болгосон оролцогчтой эхэлж хэлэлцээр хийх боловч хэлэлцээр хийхээр товлосон хугацаанд нэгдсэн шийдэлд хүрээгүй тохиолдолд тухайн хэлэлцээрийг дуусгалгүйгээр орхиж, дараагийн оролцогчтой хэлэлцээр хийх эрхтэй.

4.10.6.Ажлын хэсэг хэлэлцээрийн үр дүнд төсөл, хөтөлбөрийн болон гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохирсон нэг оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлтийг гэрээний төсөл, хөтөлбөрийн хамт Нийслэлийн байгууллагад хүргүүлнэ.

4.10.7.Нийслэлийн байгууллагууд нь саналыг судлан үзэж гэрээ байгуулах эсхүл хэлэлцээр дахин хийх, сонгон шалгаруулах ажиллагаа дахин явуулахаар буцааж болно.

4.10.8.Хэлэлцээр дахин хийх, сонгон шалгаруулах ажиллагаа дахин явуулах шийдвэр гаргасан бол тус шийдвэрт холбогдох хуулийн болон бусад үндэслэлийг тусгасан байна.

4.11. Шууд гэрээ байгуулах;

4.11.1.Дор дурдсан тохиолдолд шууд гэрээ байгуулан ТХХТ-ийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.

4.11.1.1.Сонгон шалгаруулалт явуулах нь үндэсний болон орон нутгийн аюулгүй байдалд харшлах үндэслэлтэй нь энэ талаарх хууль эрх зүйн актад тусгагдсан, эсхүл аюулгүй байдлын асуудал хариуцсан төрийн байгууллагаас энэ талаар шаардлага гаргасан;

4.11.1.2.Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай оюуны холбоотой эрх нэг буюу нэгдмэл сонирхолтой этгээдийн өмчлөлд байгаа;

4.11.1.3.Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулах урилга зарласан боловч санал ирээгүй, эсхүл шаардлагад нийцсэн санал ирээгүй бөгөөд сонгон шалгаруулалт дахин зарласан ч нэг ч этгээд сонирхлоо илэрхийлээгүй;

4.11.1.4.Нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөрийн хувьд сонгон шалгаруулалт явуулах хугацааг мөрдөх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Энэ тохиолдолд Засгийн газрын холбогдох чиглэлийн яамны шийдвэр эсхүл Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хурлын шийдвэр гарсан байх;

4.11.1.5.Хувийн хэвшлийн хуулийн этгээд, хувь хүн, төрийн бус байгууллага Нийслэлд шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөр санаачлан холбогдох тооцоо судалгааг хийж энэхүү журамд заасан шаардлага хангасан материал ирүүлсэн тохиолдолд уралдаант шалгаруулалтыг явуулж, төсөл, хөтөлбөрийн саналыг үнэлж, дүгнэлт гаргахдаа анх санаачилга гаргасан этгээдэд давуу байдал олгох бөгөөд энэ талаар уралдаант шалгаруулалтын баримт бичигт урьдчилан заана.

4.12.Сонгон шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах аль ч тохиолдолд энэхүү журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг Ажлын хэсэг байгуулан нягтлах ба Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн Нийслэлийн байгууллагуудгэрээ байгуулж ажиллана.

ТАВ. ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ, БҮРТГЭХ, МЭДЭЭЛЭХ

5.1.Гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр нийслэлд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааны талаарх хүсэлт, материалыг хүлээн авах, дүгнэлт гаргах, шийдвэрлүүлэх, гэрээ хэлэлцээр байгуулах, тайлагнах, гэрээний зүйлийг хүлээн авах, ашиглах үе шатанд ерөнхий хяналтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, үнэлгээний нэгж хэрэгжүүлнэ.

5.2.Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих эрх, үүргийг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээнд дэлгэрэнгүй тусгана.

5.3.ТХХТ-ээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн явцын болон эцсийн үр дүн, гүйцэтгэлийг мэдээлэх, тайлагнах үүргийг тухайн төсөл, хөтөлбөрийн онцлогтой уялдуулан гэрээнд нарийвчлан тусгана.

ЗУРГАА. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

6.1.Оролцох хүсэлт гаргагч болон оролцогч нь сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг Нийслэлийн байгууллагад гаргана.

6.2.Сонгон шалгаруулах ажиллагаатай холбогдсон гомдлыг тухайн ажиллагаа явагдсанаас хойш ажлын 5 өдрийн дотор гаргах бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл сонгон шалгаруулалттай холбоотой өөрийн гаргасан зардлыг шүүхээр нэхэмжлэх эрхтэй.

6.3.Нийслэлийн байгууллага нь гомдлыг шийдвэрлэж хариуг гомдол гаргагчид 14 хоногийн дотор мэдэгдэнэ.

6.4.Энэхүү журмыг зөрчсөн болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.